



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 5/145

Хэрлэн сум

**Г.Ариунхүүг түр орлон
гүйцэтгэгчээс чөлөөлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 43.3, 43.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Санхүү, төрийн сангийн хэлтсийн Зарлага хариуцсан мэргэжилтэн Малчинхүүгийн Дэлгэрзаяа нь хүүхэд асрах чөлөөнөөс үргэлжлүүлэн ажиллах болсон тул Гүрцэдэнгийн Ариунхүүг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс түр орлон гүйцэтгэгчээс чөлөөлсүгэй.

2.Г.Ариунхүүгийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга:	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Цэцэгсүрэн	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн ерөнхий Нягтлан бодогч
	Х.Баярбаатар	Төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн
	Д.Энхтуяа	Архив, бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Нярав

3.Г.Ариунхүүгийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, холбогдох тооцоог хийж дуусгахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА